



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн  
2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/16-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сэлэнгэ аймаг

2022 он

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын  
тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг:  
[enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг:  
[batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Ж.Цогт

Утас: 99886695 Цахим хаяг: [Tsogtj@audit.gov.mn](mailto:Tsogtj@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	5-10
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	5-6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7-9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9-10
3. Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүй.....	11-13
3.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	14
3.5.2 Авлага .....	14-15
3.5.3 Бараа материал .....	14-15
3.5.4 Үндсэн хөрөнгө .....	15-16
3.5.5 Өр төлбөр .....	16-17
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо.....	17
3.5.7. Орлогын данс .....	17
3.5.8. Орлогын данс .....	17-18
3.6. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	19-23
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	23
3.8. Аудитын гол асуудал .....	23
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.	23-24
3.10. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт...	24-25
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	25
4. Аудитын илрүүлэлт.....	25
4.1 Залруулга.....	27
4.2 Акт .....	26
4.3 Зөвлөмж .....	26-29
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	30-31

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв



ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ц.БАЯНБААТАР ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № СЭА-2022/16-НА-СТА-ТТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

СЭА-2022/16/-НА-СТА-ТТЗ

018020403

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	577,982.1	990,275.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	114,920.1	445,143.4
33	АВЛАГА	224,398.5	269,445.9
35	БАРАА МАТЕРИАЛ	238,663.5	275,686.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,108,561.9	13,382,114.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,108,561.9	13,382,114.2
39200	Биет хөрөнгө	11,992,749.8	13,262,233.1
39300	Биет бус хөрөнгө	115,812.1	119,881.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,686,544.0	14,372,390.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	27,002.4	101,558.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	27,002.4	101,558.9
41300	Өглөг	27,002.4	101,558.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,659,541.6	14,270,831.2
51	Засгийн газрын хувь оролцоо	12,659,541.6	14,270,831.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,072,628.9	3,076,822.9
51200	Хуримтлагдсан үр дүн	6,851,635.3	8,458,990.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,735,277.5	2,735,018.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,686,544.0	14,372,390.0

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,110,496.8	5,879,854.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	199,523.2	367,718.8
110	Орлогын албан татвар	66,494.2	131,995.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	66,494.2	131,995.8
113	Хөрөнгийн албан татвар	1,540.0	78,091.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	131,489.0	157,631.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,320,105.0	1,670,009.2
120	Нийтлэг татварын бус орлого	2,320,105.0	1,670,009.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,590,868.7	3,842,125.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,814,139.6	4,172,685.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,814,139.6	4,172,685.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,560,514.7	4,012,188.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,293,863.3	2,447,053.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	291,188.8	320,727.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	277,329.5	207,364.4

**Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2104	Хангамж, бараа материалын зардал	93,300.3	133,454.6
2105	Нормативт зардал	117,084.9	261,692.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,200.7	63,562.1
2107	Томилолт, зочны зардал	7,226.3	5,273.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,658.3	44,555.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	393,662.6	528,505.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,253,624.9	160,497.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,296,357.2	1,707,168.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	253,439.8	103,223.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	2,042,917.5	1,603,945.0

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,901,094.3	4,250,288.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	199,523.2	367,718.8
110	Орлогын албан татвар	66,494.2	131,995.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	66,494.2	131,995.8
113	Хөрөнгийн албан татвар	1,540.0	78,091.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	131,489.0	157,631.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	12,738.4	8,058.9
1181	Газрын төлбөр	26,730.6	24,574.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	92,019.9	124,999.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,614.0	116,340.1
120	Нийтлэг татварын бус орлого	98,614.0	116,340.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,602,957.1	3,766,229.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,450,894.0	3,692,814.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,450,894.0	3,692,814.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,186,125.7	3,532,564.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,293,940.6	2,447,630.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	291,229.3	320,250.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,795.8	207,364.4
2104	Хангамж, бараа материалын зардал	77,207.8	87,229.8
2105	Нормативт зардал	112,579.6	259,960.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,278.8	51,750.1
2107	Томилолт, зочны зардал	7,328.3	5,273.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,658.3	40,603.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,107.1	112,502.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,264,768.3	160,249.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	450,200.2	557,473.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	421,872.9	181,250.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	421,872.9	181,250.4
2200	Дотоод эх үүсвэрээр	421,872.9	181,250.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(421,872.9)	(181,250.4)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(43,000.0)	(46,000.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	43,000.0	46,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(14,672.6)	330,223.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	129,592.8	114,920.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	114,920.1	445,143.4

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,616,624.2	10,616,624.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	122.2	122.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,616,746.4	10,616,746.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(122.2)	(122.2)
9	Тайлант үеийн үр дүн	2,042,917.5	2,042,917.5
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,659,541.6	12,659,541.6
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	12,659,541.6	12,659,541.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	3,410.0	3,410.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,662,951.6	12,662,951.6
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(259.5)	(259.5)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	4,194.0	4,194.0
19	Тайлант үеийн үр дүн	1,603,945.0	1,603,945.0
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,270,831.2	14,270,831.2

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,943,998.9	3,556,983.6	387,015.3	90.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,551,091.2	3,407,760.1	143,331.1	96.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,477,454.1	3,334,488.8	142,965.3	95.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,400,265.6	2,349,364.5	50,901.1	97.9
210101	Үндсэн цалин	1,639,328.5	1,526,275.2	113,053.3	93.1
210102	Нэмэгдэл	552,138.6	627,405.4	(75,266.8)	113.6
210104	Урамшуулал	135,513.5	139,048.0	(3,534.5)	102.6
210105	Гэрээт ажлын хөлс	73,285.0	56,635.8	16,649.2	77.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	317,479.0	307,817.3	9,661.7	97.0
210201	Тэтгэврийн даатгал	221,908.1	215,201.7	6,706.4	97.0
210202	Тэтгэмжийн даатгал	23,892.7	23,813.0	79.7	99.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,114.3	18,827.4	286.9	98.5
210204	Ажилгүйдлийн даатгал	4,778.5	4,499.5	279.0	94.2
210205	Эрүүл мэндийн даатгал	47,785.4	45,475.6	2,309.8	95.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,742.6	207,364.3	48,378.3	81.1
210301	Гэрэл, цахилгаан	56,759.7	37,107.3	19,652.4	65.4
210302	Түлш, халаалт	172,370.1	144,064.2	28,305.9	83.6
210302	Цэвэр, бохир ус	26,612.8	26,192.8	420.0	98.4
2104	Хангамж, бараа материалын зардал	76,438.7	75,811.2	627.5	99.2

**Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210401	Бичиг хэрэг	10,860.5	10,487.0	373.5	96.6
210402	Тээвэр, шатахуун	40,368.2	40,331.0	37.2	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,032.7	8,946.6	86.1	99.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,761.0	5,751.2	9.8	99.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,343.4	8,222.9	120.5	98.6
2105	Нормативт зардал	162,993.2	142,983.7	20,009.5	87.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	36,600.2	36,583.8	16.4	100.0
210503	Хоол, хүнс	110,549.0	90,556.8	19,992.2	81.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,844.0	15,843.1	0.9	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,082.4	110,749.5	2,332.9	97.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	61,447.2	61,381.2	66.0	99.9
210602	Тавилга	10,850.0	10,850.0	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	641.7	641.7	-	100.0
210604	Урсгал засвар	40,143.5	37,876.6	2,266.9	94.4
2107	Томилолт, зочны зардал	6,717.2	4,560.4	2,156.8	67.9
210702	Дотоод албан томилолт	6,717.2	4,560.4	2,156.8	67.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,049.5	33,107.8	3,941.7	89.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,122.4	29,235.1	2,887.3	91.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,320.5	2,448.0	872.5	73.7
210803	Даатгалын үйлчилгээ	416.7	351.9	64.8	84.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	927.5	861.6	65.9	92.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	139.3	88.0	51.3	63.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	123.1	123.1	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,685.9	102,730.1	4,955.8	95.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,998.8	88,588.4	4,410.4	95.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,687.1	14,141.7	545.4	96.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,637.1	73,271.3	365.8	99.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,637.1	73,271.3	365.8	99.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	44,305.0	43,939.2	365.8	99.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,292.8	21,292.8	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,039.3	8,039.3	-	100.0
22	Хөрөнгийн зардал	307,677.6	103,223.5	204,454.1	33.5
220001	Барилга байгууламж	260,585.2	85,805.6	174,779.6	32.9
221001	Их засвар	12,027.4	-	12,027.4	-
222001	Тоног төхөөрөмж	16,480.0	12,479.2	4,000.8	75.7
223001	Бусад хөрөнгө	12,585.0	4,938.7	7,646.3	39.2
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	91,230.1	46,000.0	45,230.1	50.4
230001	Эргэж төлөгдөх зээл	91,230.1	46,000.0	45,230.1	50.4
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,943,998.9	3,655,156.1	288,842.8	92.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,501,522.8	2,460,761.8	40,761.0	98.4
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,501,522.8	2,460,761.8	40,761.0	98.4

**Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,273,946.0	1,067,176.1	206,769.9	83.8
320001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,116,318.6	909,548.7	206,769.9	81.5
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	157,627.4	157,627.4	-	100.0
33	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	50,670.0	31,853.0	18,817.0	62.9
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	50,670.0	31,853.0	18,817.0	62.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	117,860.1	95,365.1	22,495.0	80.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,132.9	94,865.1	(9,732.2)	111.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500.0	500.0	-	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	33,227.2	-	33,227.2	-
6	Төсвийн бусад мэдээллийн ангилал	1,795.0	2,321.0	(526.0)	129.3
61	Байгууллагын тоо	11.0	11.0	-	100.0
610001	Төсвийн байгууллага	11.0	11.0	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	196.0	199.0	(3.0)	101.5
620001	Удирдах ажилтан	17.0	17.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	109.0	108.0	1.0	99.1
620003	Үйлчлэх ажилтан	65.0	69.0	(4.0)	106.2
620004	Гэрээт ажилтан	5.0	5.0	-	100.0
63	Суралцагчдын тоо	1,392.0	1,339.0	53.0	96.2
630	Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид	1,055.0	1,055.0	-	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	1,055.0	1,055.0	-	100.0
631	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	337.0	284.0	53.0	84.3
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	337.0	284.0	53.0	84.3
64	Эмчлүүлэгсдийн тоо	-	573.0	(573.0)	#DIV/0!
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	-	573.0	(573.0)	#DIV/0!
65	Орон тооны мэдээлэл	196.0	199.0	(3.0)	101.5
650001	Төрийн захиргааны албан хаагч ТЗ	12.0	12.0	-	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч ТҮБД	110.0	115.0	(5.0)	104.5
650006	Соёл урлагын салбарын төрийн үйлчилгээний албан хаагч ТҮСУ	6.0	5.0	1.0	83.3
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч ТҮЭМ	26.0	26.0	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	36.0	35.0	1.0	97.2
650011	Улс төрийн албан хаагч	6.0	6.0	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	320,750.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	320,750.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	274,532.6

**Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	98,266.1
210101	Үндсэн цалин	100.7
210102	Нэмэгдэл	87,805.6
210104	Урамшуулал	10,359.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,433.0
210201	Тэтгэврийн даатгал	8,336.4
210202	Тэтгэмжийн даатгал	1,130.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	512.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,072.1
210205	Эрүүл мэндийн даатгал	1,381.2
2104	Хангамж, бараа материалын зардал	13,415.6
210401	Бичиг хэрэг	1,235.1
210402	Тээвэр, шатахуун	8,923.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	342.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,326.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,588.7
2105	Нормативт зардал	116,976.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	104,552.3
210502	Хоол, хүнс	8,294.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,130.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,159.5
210604	Урсгал засвар	3,424.9
2107	Томилолт, зочны зардал	713.0
210702	Дотоод албан томилолт	713.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,366.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,366.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,202.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,202.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,217.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,800.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,800.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,417.5
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10.3
2013405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,407.2
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	320,750.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	320,750.1
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,600.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	248,997.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,152.3

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн /цаашид Цагааннуур сумын ТТЗ гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төлбөрийн цахим баримт, анхан шатны баримтын бүрдэл, мөнгөн кассын журам болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цагааннуур сумын ТТЗ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цагааннуур сумын ТТЗ-ийн эрхэм зорилго нь *“Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх замаар нутаг орондоо ая тухтай ажиллаж амьдрах эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдүүлэхэд сумын Засаг даргыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын мэдээллээр хангах, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааны үр нөлөөтэй, үр ашигтай, тасралтгүй жигд хэвийн нөхцөлийг баталгаатай хангах замаар улс төрийн аливаа нөлөөлөлд авталгүй, иргэддээ үнэнч шударга үйлчлэх”*-д оршино гэж тодорхойлжээ.

Цагааннуур сумын ТТЗ нь тайлант онд дараах үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,

- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд сумын Засаг даргын баталсан “Дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө”-ний дагуу сумын Санхүүгийн албанаас харьяа төр, төсвийн байгууллагуудад төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд улирал тутамд дотоод хяналт, шалгалт хийж, санхүү, нягтлан бодох бүртгэл, шилэн дансны мэдээлэлд 9 зөвлөмж өгч, гарсан алдаа, зөрчлийн талаар холбогдох төр, төсвийн шууд захирагч нарт танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгсөн байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагааннуур сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 4,172,685.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 41,726.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 29,208.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 114,920.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 445,143.4 мянган төгрөг болж, 330,223.3 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	114,920.1	445,143.4	330,223.3	74.2
<b>Дүн</b>	<b>114,920.1</b>	<b>445,143.4</b>	<b>330,112.3</b>	<b>74.2</b>

*Эх сурвалж: Цагааннуур сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан 314,689.6 мянган төгрөг орон нутгийн ерөнхий орлогын дансанд, 74,468.1 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 55,985.7 мянган төгрөг СХС-ийн дансанд тус тус байршиж байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 224,398.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 269,445.9 мянган төгрөг болж, 45,047.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	3,461.3	3,461.3	
Татаас, санхүүжилтийн авлага	4,219.1	78,844.6	74,625.5
Зээлийн хүүгийн авлага	9,333.1	8,402.7	(930.4)
Бусад авлага	57.3	57.3	-
Зээлийн авлага	207,327.6	178,679.9	(28,647.7)
<b>Дүн</b>	<b>224,398.5</b>	<b>269,445.9</b>	<b>45,047.4</b>

Эх сурвалж: Цагааннуур сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 6,365.8 мянган төгрөгийн авлага байгаагаас татаас санхүүжилтийн авлагын 2,847.2 мянган төгрөг, ажилчдаас авах авлагын 3,461.3 мянган төгрөг, байгууллагаас авах авлагын 57.3 мянган төгрөг, СХС-ийн 2012-2017 онуудад олгосон эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн 59,891.2 мянган төгрөгийн болон зээлийн хүүгийн авлагын 4,170.3 мянган төгрөг зэрэг авлагууд бүртгэлтэй байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 66.3 хувь буюу 178,679.9 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

Насжилт өндөртэй /3-аас дээш жил/ СХС-ийн зээлийн 70,521.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандаж 8 иргэний нийт 59,111.7 мянган төгрөгийн нэхэмжлэлийг хүргүүлж, 3 иргэнийг Шүүхийн шийдвэрийн дагуу эрэн сурвалжлах ажил арга хэмжээ авч ажилласан байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 238,663.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 275,686.6 мянган төгрөг болж 37,023.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	1,591.5	3,023.5	1,432.0
Эм боох материал	10,227.2	15,481.3	5,254.1
Бичиг хэргийн материал	107.8	109.5	1.7
Аж ахуйн материал	207,624.8	240,293.6	32,668.8
Хүнсний материал	712.4	3,167.8	2,455.4
Бусад хангамжийн материал	18,399.8	13,610.8	(5,239.0)
<b>Дүн</b>	<b>238,663.5</b>	<b>275,686.6</b>	<b>37,023.1</b>

Эх сурвалж: Цагааннуур сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 37,023.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 676,968.3 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, хандив, тусламжаар 54,852.6 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан, данснаас дансанд 92,044.3 мянган төгрөгийг шилжүүлсэн зэргээр нийт 731,820.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 573,419.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 92,044.3 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн, 29,333.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассанаас шалтгаалсан байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл /анхны өртгөөр/ 14,249,935.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 15,610,934.4 мянган төгрөг болж 1,360,999.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

**Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	11,390,444.4	11,394,966.9	4,522.5
Хуримтлагдсан элэгдэл	(1,191,073.6)	(1,352,959.4)	(161,885.8)
Авто-тээврийн хэрэгсэл	293,393.8	258,375.8	(35,018.0)
Хуримтлагдсан элэгдэл	(198,011.5)	(185,113.6)	12,897.9
Машин тоног төхөөрөмж (компьютер)	759,959.7	801,902.9	41,943.2
Хуримтлагдсан элэгдэл	(412,141.9)	(320,813.5)	91,328.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	390,297.8	419,851.5	29,553.7
Хуримтлагдсан элэгдэл	(159,036.5)	(187,661.6)	(28,625.1)
Бусад үндсэн хөрөнгө	1,233,770.1	2,542,800.9	1,309,030.8
Хуримтлагдсан элэгдэл	(180,247.1)	(267,089.9)	(86,842.8)
Ном	65,394.6	72,167.4	6,772.8
Программ хангамж	1,290.0	1,290.0	-
Хуримтлагдсан элэгдэл	(862.9)	(987.9)	(125.0)
Бусад биет бус хөрөнгө	115,385.0	119,579.0	4,194.0
<b>Дүн</b>	<b>12,108,561.9</b>	<b>13,382,114.2</b>	<b>1,273,552.3</b>

*Эх сурвалж: Цагааннуур сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 78,026.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив, тусламжаар 46,626.8 мянган төгрөг, үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 1,305,150.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, акталж устгасан 68,804.7 мянган төгрөгөөр хасагдсан байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 27,002.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 101,558.9 мянган төгрөг болж, 74,556.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	27,002.4	101,558.9	74,556.5	73.4
Ажиллагсадтай холбоотой өглөг				
Бараа үйлчилгээний зардлын өглөг	24,533.7	43,935.2	19,401.5	44.2
Байгууллагад төлөх өглөг	2,468.7	57,623.7	55,155.0	95.7
<b>Нийт дүн</b>	<b>27,002.4</b>	<b>101,558.9</b>	<b>74,556.5</b>	<b>73.4</b>

*Эх сурвалж: Цагааннуур сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 2021 оны санхүүжилтийн хүрэлцээгүйгээс Спорт цогцолборын халаалтын 24,533.7 мянган төгрөгийн, ОНЕО-ын 2,468.7 мянган төгрөг /2012 онд үүссэн ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт

**Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

санхүүжилтийн дансанд байршсан хөтөлбөрийн зардлын үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн/, ЭМТ нь ковид -19 цар тахалтай холбоотой эм, эмнэгийн хэрэгслийн 74,556.5 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 12,659,541.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 14,270,831.3 мянган төгрөг болж, 1,611,289.6 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,072,628.9	3,076,822.9	4,194.0	0.1
Хуримтлагдсан үр дүн	6,851,635.3	8,458,990.3	1,607,355.0	19.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,735,277.5	2,735,018.1	(259.4)	(0.01)
<b>Дүн</b>	<b>12,659,541.7</b>	<b>14,270,831.3</b>	<b>1,611,289.6</b>	<b>11.3</b>

*Эх сурвалж: Цагааннуур сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь 1,305,150.0 мянган төгрөгийн үнэ бүхий тариалангийн талбайн хашааг хөрөнгөд бүртгэснээс голлон шалтгаалжээ.

### 3.5.7 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон сумын ЗДТГ-ын түрээсийн төлбөрийн 500.0 мянган төгрөг, Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн ангийн талбай тусгаарлалтын төлбөрийн 16,612.5 мянган төгрөгийн өөрийн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлсэн байна.

### 3.5.8 Зардлын данс

Тайлант онд зардлын дансадтай холбоотой **63,645.0 мянган** төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

#### **Аудитын илрүүлэлт:**

##### **1. Төсвийн төвлөрүүлэн захирагч:**

- Аймгийн төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогыг зайлшгүй шаардлага үүсээгүй байхад буюу сумын ИТХ, соёлын төвийн урсгал зардлыг *ИИТХ-ын тавилга, эд хогшлын зардалд 2,000.0 мянган төгрөг, Соёлын төвийн урсгал засварын зардалд 5,000.0 мянган төгрөг/* санхүүжүүлэхэд **7,000.0 мянган** төгрөгийн санхүүжилтийг нэмэгдүүлэн тодотгосон,

- Тайлант онд нийт **16,096.1 мянган** төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй.

**2. Засаг даргын Тамгын газар:**

- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс зардлын бүлэг хооронд нийт 8,590.6 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,

**3. Эрүүл мэндийн төв:**

- Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын 10,608.0 мянган төгрөгийн орлого, эмийн сангийн 13,295.6 мянган төгрөгийн кассын орлого, зэрэг нийт **23,903.6 мянган** төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр тушаасан,
- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс зардлын бүлэг хооронд нийт 1,000.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,

**4. Сэлэнгэ бүсийн Сүм дундын ойн анги:**

- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс зардлын бүлэг хооронд нийт 1,750.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,

**5. Соёлын төв:**

- Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн 3 жилийн дунджаар бус сүүлийн сарын үндсэн цалингаар тооцож соёлын төвийн номын санч Ц.Сүглэгмаад **1,380.2 мянган** төгрөгийг илүү олгосон,
- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс зардлын бүлэг хооронд нийт 1,125.6 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,

**6. 1 дүгээр цэцэрлэг:**

- Тайлант онд 1,500.0 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй,

**7. 2 дугаар цэцэрлэг:**

- Тайлант онд 1,298.9 мянган төгрөгийн хүнсний материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Цагааннуур сумын ИТХ-ын “2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 2021 оны 36 дугаар тогтоолоор тайлант онд 288,270.0 мянган төгрөгийн татварын орлого, 17,980.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 388,693.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 26.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

*Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт ийн хувь
Хувь хүний орлогын албан татвар	53,000.0	65,458.1	12,458.1	123.5
Бууны албан татвар	1,500.0	1,901.0	401.0	126.7
Улсын тэмдэгтийн хураамж	2,800.0	5,433.9	2,633.9	194.1
Агнуурын нөөц ашигласны төлбөр	400.0	-	(400.0)	-
Байгалийн ургамал ашигласны төлбөр	90.0	1,461.6	1,371.6	16.0 дах
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	48,722.8	123,537.3	74,814.5	2.5 дах
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	125.0	125.0	-	100.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,500.0	2,500.0	-	100.0
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	7,200.0	13,077.4	5,877.4	181.6
Газрын төлбөрийн орлого	23,647.0	24,573.9	926.9	103.9
Хадгаламжийн хүүгийн орлого	28,300.0	53,460.3	25,160.3	188.9
Малын тоо толгойн албан татвар	119,985.2	76,190.2	(43,795.0)	63.5
Хүү, торгуулийн болон бусад орлого	17,980.0	20,974.9	2,994.1	116.7
<b>Нийт дүн</b>	<b>306,250.0</b>	<b>388,693.7</b>	<b>82,843.6</b>	<b>126.9</b>

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 74,814.5 мянган төгрөгөөр, хадгаламжийн хүүгийн орлого 25,160.3 мянган төгрөгөөр, хувь хүний орлогын албан татварын орлого 12,458.1 мянган төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 5,877.4 мянган төгрөгөөр, хүү, торгуулийн болон бусад орлого 2,994.1 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 2,633.9 мянган төгрөгөөр, ургамал ашигласны төлбөр 1,371.6 мянган төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 926.9 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

### **Давж биелсэн орлогууд:**

- Хувь хүний орлогын албан татвар 12,458.1 мянган төгрөгөөр давж биелсэн нь татварын албаны программын шинэчлэлтэй холбоотой харьяаллын дагуу татвар төвлөрүүлдэг болсон болон малчдад олгосон ноос ноолуур, хүнсний улаан буудайн урамшууллаас ХХОАТ тооцсонтой холбоотой,
- Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого 74,814.5 мянган төгрөгөөр давсан нь ЗГ-ын тогтоолоор гоожингийн М<sup>3</sup>-ийн үнэ 2.5-3.2 дахин өссөнтэй холбоотой,
- Хадгаламжийн хүүгийн орлого 25,160.3 мянган төгрөгөөр давсан нь орлогын төлөвлөгөөг бага төлөвлөсөнтэй холбоотой,
- Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 5,877.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь тус суманд нотариатын үйлчилгээ тогтмол хийгдэж, үл хөдлөх хөрөнгийн болон бусад хөрөнгийн гэрээ сумандаа хийгдэж байгаатай холбоотой,
- Хүү, торгуулийн болон бусад орлого 2,994.1 мянган төгрөгөөр давсан нь цагдаагийн тасаг нь согтуурал хэмжигч болон торгуулийн машинтай болсноос голлон шалтгаалсан байна.

### **Тасарсан орлогууд:**

- Аг агнуурын нөөц ашигласны төлбөр нь ковид 19, малын шүлхий өвчний улмаас хөл хорио хязгаарлалттай байсан учраас.
- Малын тоо толгойн албан татвар нь малын 1 тоо толгойд ногдуулсан татварын хэмжээг сумын ИТХ-ын тогтоолоор тогтоосон боловч, Хууль зүйн яамнаас 12 сарын 10-наас хойш батлагдсанаас татвар хураах ажиллагаа оройтсонтой холбоотой байна.

### **Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 3,949,244.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өргөн барьсан төсвийн төслийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 13 дугаар тогтоолоор нийт орлого, зарлагыг тус бүр 3,949,244.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын төсөвт хийгдсэн нийт 3 удаагийн тодотгол болон зохицуулалтаар дараах өөрчлөлтүүд орж сумын төсвийн орлого, зарлагыг тус бүр **3,943,998.9** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- ***ИТХ-ын 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 31 дүгээр тогтоол:***
  - Сумын татварын орлогын төлөвлөгөөг 40,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон,
  - Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих ЕБС-ийн санхүүжилтийг 71,230.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1, 2-р цэцэрлэгийн санхүүжилтийг 22,597.6 мянган төгрөгөөр бууруулсан,
  - Сумын хөрөнгө оруулалт болон ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг 102,415.0 мянган төгрөгөөр бууруулсан,

- Ковид-19 цар тахал болон малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан ЗДНХ-ийн зардлыг 46,768.3 мянган төгрөгөөр, багийн цалин, НДШ-ийг 2,000.1 мянган төгрөгөөр, ИТХ-ын цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 2,189.7 мянган төгрөгөөр, тавилга, эд хогшлын зардал 2,000.0 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 18,498.7 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 10,185.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн,
- Соёлын төвийн урсгал засварт 5,000.0 мянган төгрөг, ном хэвлэлийн зардалд 1,000.0 мянган төгрөг, 484.7 мянган төгрөгийг шуудан холбоо, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардалд 327.3 мянган төгрөг зэрэг нийт 6,812.0 мянган төгрөгийг нэмсэн,
- Хот тохижилтын зардлыг 6,908.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн,
- Аймгаас суманд өгөх санхүүгийн дэмжлэгээс Спорт цогцолборын тогтмол зардлыг 65,000.0 мянган төгрөгөөр бууруулсан,
- **2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 34 дүгээр тогтоол:**
  - Малын тоо толгойн албан татварыг 119,985.2 мянган төгрөгөөр нэмж, сумын ОНХС-д 2 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 119,985.2 мянган төгрөгийг нэмж тодотгосон,
- **2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 36 дугаар тогтоол:**
  - Засгийн газрын 43 дугаар тогтоолтой холбоотойгоор сумын хөрөнгө оруулалтыг 80,000.0 мянган төгрөгөөр бууруулж, баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрт зориулан **3,943,998.9** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,564,651.2 мянган төгрөгийг урсгал зардалд, 285,197.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 94,150.1 мянган төгрөгийг зарцуулахаар тогтоожээ.

Тайлант онд сумын ИТХ-ын тогтоолоор төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан 3,015,934.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч сургууль, цэцэрлэгийн батлагдсан төсөвт өөрчлөлт орсноор **3,031,781.1** мянган төгрөгөөр эцэслэн батлагдаж 2,560,652.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 321,128.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 150,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар тогтоосон байна.

Нийт зардлын 2,501,522.8 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 741,068.6 мянган төгрөгийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс, 306,250.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 50,670.0 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 69,507.9 мянган төгрөгийг СХС-ийн эргэн төлөлтөөс, 16,125.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 157,627.4 мянган төгрөгийг ОНХС-аас, 101,227.2 /ОНЕО-ын 69,000.0 мянган төгрөг, ОНХС-ийн 7,585.0 мянган төгрөг, СХС-ийн 24,642.2 мянган төгрөг/ мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авах санхүүгийн дэмжлэг 741,068.6 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 2,501,522.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 168,480.1 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 31,853.0 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 17,112.5 мянган төгрөг, ОНХС-аас

157,627.4 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 78,252.6 мянган төгрөг зэрэг нийт **3,695,917.0** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,556,983.6 мянган төгрөг буюу 90.2 хувьтай тайлагнагдсан нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 60,562.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 48,378.3 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 627.5 мянган төгрөгөөр, нормативт зардал 20,009.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 2,332.9 мянган төгрөгөөр, албан томилолтын зардал 2,156.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 3,941.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 4,955.8 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 365.8 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 198,454.1 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээл 45,230.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2 төсөл арга хэмжээнд 16,480.0 мянган төгрөг, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 6 төсөл, арга хэмжээнд 165,212.4 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтад 12,479.2 мянган төгрөг, ОНХС-д 90,744.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчдаас 170,247.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 61,152.3 мянган төгрөг, ЭМДС-ийн нэмэлт орлого 78,749.9 мянган төгрөг, хандив тусламж 10,600.0 мянган төгрөг зэрэг нийт 320,750.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Үүнд:

#### **Дээд шатны төсвийн захирагчдаас:**

- Аймгийн Статистикийн хэлтсээс 2,963.8 мянган төгрөг,
- Сумын ЭМТ-д аймгийн ЭМГ-аас цар тахлын үед ажилласан албан хаагчдын илүү цагийн хөлс, ЭМДС-аас ковидын хэвтэн эмчлүүлэгчийн, гэрийн эргэлтийн, вакцин дархлаажуулалтын, 1 удаагийн буцалтгүй тусламж зэрэгт 163,528.5 мянган төгрөг,
- Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн ангийн орлогод дээд шатны төсвийн захирагчаас 2,000.0 мянган төгрөг,
- Аймгийн БСУГ-аас ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 1,2 дугаар цэцэрлэгт 521.6 мянган төгрөг, ЕБС-д 934.0 мянган төгрөг,

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд ИТХ-д 300.0 мянган төгрөг зэргийг тус тус шилжүүлсэн байна.

#### **Үндсэн үйл ажиллагааны хүрээнд:**

- ЗДТГ нь сумын байрны түрээсийн төлбөрийн 4,112.8 мянган төгрөг,
- Сэлэнгэ бүсийн сум дундын Ойн анги нь талбай тусгаарлалтын төлбөрийн 21,130.9 мянган төгрөг,
- Соёлын төв нь талбай түрээсийн төлбөрийн 1,705.0 мянган төгрөг,
- ЭМТ нь эргэлтийн эмийн сангийн орлого 29,308.6 мянган төгрөг,
- ЕБС-ийн номын түрээсийн орлого 4,895.0 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэн ажилласан байна.

Үүнээс цалин, НДШ-ийн зардалд 110,699.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 13,415.6 мянган төгрөг, нормативт зардалд 116,976.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 8,159.5 мянган төгрөг, томилолтын зардалд 713.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 16,366.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 8,202.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулалд 32,800.0 мянган төгрөг тус тус зарцуулж, 13,417.5 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

#### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Аудитаар онцлох асуудалгүй.

#### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

#### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### **3.9.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийн хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

- ТТЗ нь 151 мэдээлэл байршуулахаас бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

- ЗДТГ нь 151 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- ИТХ нь 151 мэдээлэл байршуулахаас бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.
- ЭМТ нь 151 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- Соёлын төв нь 151 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож, 6 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
- Сум дундын ойн анги нь 151 мэдээлэл байршуулахаас 6 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

1. ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *“....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”* гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй дараах байгууллагууд байна. Үүнд:

- ИТХ-ын тайлант оны үйл ажиллагаанд 66,692.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 65,593.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 1.6 хувиар хэмнэсэн,
- ЗДТГ-ын тайлант оны үйл ажиллагаанд 568,372.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 540,864.3 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4.8 хувиар хэмнэсэн,
- Сэлэнгэ бүсийн Сум дундын ойн ангийн тайлант оны үйл ажиллагаанд 43,305.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 43,097.6 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.5 хувиар тус тус хэмнэсэн байна.

2. ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-т: *“....бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”* гэж заасныг дараах байгууллагууд зөрчсөн байна. Үүнд:

- ИТХ нь 2,000.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил,
- ЗДТГ нь 7,850.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил,
- Ойн анги нь 569.3 мянган төгрөгийн нормын хувцас зэргийг худалдан авсан байна.

### **3.10 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 2,998.3 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт, 13,825.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, 74,205.5 мянган төгрөгийн 7 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	2,998.3	4	2,998.3	-	-	100
Албан шаардлага	5	13,825.8	5	13,825.8	-	-	100
Зөвлөмж	7	74,205.5	7	74,205.5	-	-	100
<b>Нийт дүн</b>	<b>16</b>	<b>91,029.6</b>	<b>16</b>	<b>91,029.6</b>	-	-	<b>100.0</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

## 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 8, орон нутгийн төсөл сангийн 2, нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс, ЕБС, 1,2 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, 5 байгууллага, 2 төсөл сангийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Цагааннуур сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 67,813.2 мянган төгрөгийн 16 алдаа, зөрчил илрүүлснээс 4,168.2 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 1,380.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 62,264.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 10 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитад хамрагдсан харьяа 3 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

**ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 65,014.3 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илрүүлснээс 4,168.2 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 1,380.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 59,465.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүллээ.**

### 4.1 Залруулга:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тайлагналын алдаатай **4,168.2** мянган төгрөгийн залруулгыг санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

**ЗДТГ:**

- Үндсэн хөрөнгөд 292.4 мянган төгрөгийн элэгдэл байгуулаагүй,

**ЭМТ:**

- Авлагын үлдэгдэлд 1,440.9 мянган төгрөгийн Нийгмийн даатгалаас авах авлагыг тайлагнаагүй,
- Тайлант оны элэгдлийн зардлын дүн нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн элэгдлийн дүнгээс 499.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Үндсэн хөрөнгөд 1,533.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулаагүй,

**Ойн анги:**

- Үндсэн хөрөнгөд 402.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулалгүйгээр тайлагнасан байсныг аудитын явцад залруулж, залруулсан алдаагаар бүртгэв.

**4.2 Төлбөрийн акт:**

**4.2.1** Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн 3 жилийн дунджаар бус сүүлийн сарын үндсэн цалингаар тооцож соёлын төвийн номын санч Ц.Сүглэгмаад **1,380.2 мянган** төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно” гэсэн заалтуудыг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэг удаагийн буцалтгүй тусламжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

**4.3 Зөвлөмж:**

**4.3.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

**1.1 Илрүүлэлт:** Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс дараах байгууллагууд хөтөлбөр болон зардлын бүлэг хооронд нийт **12,466.2 мянган** төгрөгийг гүйлгэн зарцуулсан зөрчил гаргасан байна. Үүнд:

**Засаг даргын Тамгын газар:**

- Батлагдсан төсвөөс сумын Цагдаагийн тасагт 2,921.6 мянган төгрөгийн согтуурал хэмжигч худалдан авсан,
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамжаас 5,669.0 мянган төгрөгийн бараа, материал худалдан авсан,

**Эрүүл мэндийн төв:**

- Тавилгын зардлаас 1,000.0 мянган төгрөгийн багаж, техник хэрэгсэл худалдан авсан,

#### **Сэлэнгэ бүсийн Сум дундын ойн анги:**

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамжаас 1,750.0 мянган төгрөгийн бараа, материал худалдан авсан,

#### **Соёлын төв:**

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамжаас 1,125.6 мянган төгрөгийн бараа, материал худалдан авсан,

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг зөрчиж байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

### **4.3.2 Төсвийн тодотголтой холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт: Аймгийн төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогыг зайлшгүй шаардлага үүсээгүй байхад буюу сумын ИТХ, соёлын төвийн урсгал зардлыг *ИТХ-ын тавилга, эд хогшлын зардалд 2,000.0 мянган төгрөг, Соёлын төвийн урсгал засварын зардалд 5,000.0 мянган төгрөг/ санхүүжүүлэхэд 7,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийсэн байна.*

2.2 Өгсөн зөвлөмж: Уг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 34.2.2: “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон” гэсэн заалтуудыг зөрчсөн тул зайлшгүй нөхцөл бий болоогүй байхад байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхээр төсөвт тодотгол хийхгүй байх.

### **4.3.3 Мөнгөн кассын ажиллагааны журамтай холбоотой асуудал:**

3.1 Илрүүлэлт: ЭМТ нь Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын 10,608.0 мянган төгрөгийн орлого, эмийн сангийн 13,295.6 мянган төгрөгийн кассын орлого, зэрэг нийт **23,903.6 мянган** төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр тушаасан байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12 дэх “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд **ажлын 1 хоногт багтаан** тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой

байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Цаашид тухай бүр өөрийн орлогыг харилцах дансанд тушааж, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөн ажиллах.

#### **4.3.4 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:**

4.1 Илрүүлэлт: ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг тулган шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ЗДТГ нь 151 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- ЭМТ нь 151 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- Соёлын төв нь 151 мэдээлэл байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож, 6 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
- Сум дундын ойн анги нь 151 мэдээлэл байршуулахаас 6 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1- 6.4, 6.10 дахь заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

#### **4.3.5 Анхан шатны болон цахим төлбөрийн баримттай холбоотой асуудал:**

5.1 Илрүүлэлт: Тайлант онд нийт **16,096.1 мянган** төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Үүнд:

- Сумын ЗДТГ нь 5,268.0 мянган төгрөг,
- ИТХ нь 1,340.0 мянган төгрөг,
- ЭМТ нь 7,520.0 мянган төгрөг,
- Соёлын төв нь 1,128.1 мянган төгрөг,
- Ойн анги нь 840.0 мянган төгрөг.

5.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан “загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
				/мянган төгрөгөөр/												
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар</b>																
1			Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн 3 жилийн дунджаар бус сүүлийн сарын үндсэн цалингаар тооцож соёлын төвийн номын санч Ц.Сүглэгмаад илүү олгосон.	1	1,380.2			1	1,380.2							
2	ТТ3	СЭА-2022/16-НА-СТА-ТТ3	Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс ЗДТГ нь 8,590.6 мянган төгрөг, ЭМТ нь 1,000.0 мянган төгрөг, Ойн анги нь 1,750.0 мянган төгрөг, Соёлын төв нь 1,125.6 мянган төгрөг зэрэг нийт 12,466.2 мянган төргийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан	1	12,466.2								1	12,466.2		
3			Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад ИТХ, Соёлын төвийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр төсөвт тодотгол хийсэн.	1	7,000.0										1	7,000.0
4			ЭМТ нь ковид 19 өвчнийг илрүүлэх оношлуурын орлого, эмийн сангийн кассын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр тушаасан.	1	23,903.6										1	23,903.6

